# БАЯНТАЛ СУМЫН 14 ХОНОГИЙН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ



**2023 оны 05 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дүгээр сарын 29-ний хооронд хийгдсэн ажлуудаас**

# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Засаг дарга , Засаг даргын Тамгын газарт ирсэн, явсан, хариутай албан бичиг, өргөдөл гомдолын шийдвэрлэлтийн талаар тайлагнахад,

- 1. Ирсэн албан бичиг -41
- -Үүнээс:
- Бүртгэл хяналтын карт хөтөлсөн хариутай албан бичиг -9
- Хугацаандаа явсан хариутай албан бичиг -1
- Хугацаа хоцорсон -2
- Хугацаа болоогүй-6
- 2. Явуулсан албан бичиг-23
- **Захирамж, Тушаал**
- Захирамж “А”-1 гарсан
- Тушаал “А”-1 гарсан
- **Өргөдөл, гомдолын шийдвэрлэлт**
- **1. Засаг даргад ирсэн өргөдөл-1**
- -Худаг гаргах зөвшөөрөл хүссэн /шийдвэрлэх хугацаа болоогүй /
- **2. Засаг даргын Тамгын газарт ирсэн өргөдөл -2**
- -Хүлэмж олгож өгнө /1 иргэнд хүлэмжийг олгохоор шийдвэрлэсэн.

E-mongolia цахим үйлчилгээ хэвийн ажиллаж байна.



# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Говьсүмбэр аймгийн Соёл урлагийн газар болон Нийтийн Номын сангийн албан хаагчид сумын Соёлын төвд 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдөр үйл ажиллагаатай нь танилцаж аргазүйн зөвлөгөө өгсөн байна.

















05 дугаар сарын 22-ны өдөр сумын ЗДТГазар, Соёлын төв, ЭМТөв, Цагдаагийн хэсэгтэй хамтран 1-р багийн иргэдэд явуулын үйлчилгээ зохион байгууллаа. Тус арга хэмжээнд иргэд болон хүүхэд багачуудын дунд АХА тэмцээн, Номын сангийн иж бүрэн үйлчилгээ, ОНСТ-ын музейг VRBox-оор үзүүлэх, гарын авлага тараах, Түмэн дасгал хамтран хийх, иргэдийн угийн бичгийн хөтлөлтийн судалгаа, амбулаторийн үзлэг оношилгоо авах зэрэг үйлчилгээнүүдийг 78 хүнд үзүүлж ажиллаа.

1-р багийн зүүн баруун гэр хороолол болон 152, 154 дүгээр байрны оршин суугчдад эрүүл мэндийн үйлчилгээ явуулын амбулаторийн үзлэг оношилгоог 24 хүнд хийгдсэн байна.

# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Боржигон чуулгад болсон Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэгт Баянтал сумын иргэдийг хамруулах, бичгээр санал авах ажлыг зохион байгуулав.

1.



Аймгийн Засаг даргын тамгын газрын хууль эрх зүйн хэлтэс, хүний эрхийн үндэсний комиссын аймаг дахь референт, "Иргэдийн шударга шүүх" ТББ-аас зохион байгуулсан Хүний эрхийн ойлголт, хүний эрхэд суурилсан хандлага, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль, Монгол улсын Үндсэн хуулийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэн сурталчилах сургалтад иргэдийг хамруулсан.






# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр ЗДТГазрын албан хаагчид Оорцог-Элгэн зөрлөгийн А/0101 зам дагуух хог, хогийн цэгийн 7,5 тн хог хаягдалыг цэвэрлэж зайлуулсан. Наран-Элгэн зөрлөгийн самбартай хөтөлийн босоо тэнхлэгийн зам дагуух хог, хогийн цэгийн 5 тн хог хаядал, нийт 12,5 тн хогийг цэвэрлэж зайлуулсан байна.











МЭДЭГДЭХ ХУУДАС

Багийн иргэн ........ танаа

Мал бүхий иргэн та Сумын төвийн харьяалалын нутаг дэвсгэрт байрлах ногооны талбай болон хүлэмж, тариалсан мод бут, ногоон байгууламжруу өөрийн малыг бэлчээрлүүлэхгүй, байнгын хариуцлагатай байх мэдэгдлийг хүргүүлж байна. Хэрэв зөрчил гарвал Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 8 дугаар зүйл 8.1.1, 8.1.6.дахь заалтыг үндэслэн хариуцлага тооцох болно.

ЛУН БАГИЙН ДАРГА Э.ТУМЭН-ЭРДЭНЭ



Сумын суурьшлын бүсийн мал бүхий иргэдэд төвд малаа бэлчээхгүй байх албан мэдэгдлийг багийн Засаг даргаар хүргүүлж ажилласан.

# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

"Эрүүл монгол хүн" төслийн хүрээнд 05 сарын 12-оос 21-ний өдрүүдэд зохион байгуулагдаж буй аймгийн Засаг даргын нэрэмжит "Спортын бага наадам"-д Баянтал сумаас Сумын Засаг даргын орлогч Э.Эрхэмбаатар ахлагчтай Талын шонхор баг 45 тамирчны бүрэлдэхүүнтэй оролцсон байна. Хөл бөмбөгийн төрөлд Мөнгөн медаль хүртсэн.





"Залуусын манлайлал" Говьсүмбэр аймгийн залуучуудын чуулганд 2023 оны 05 сарын 26-ны өдөр оролцсон.





Нийтийн биеийн тамир, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлэх зорилгоор 05 дугаар сарын 24-ны өдөр "фалунь дафа" бясалгалын багш нарыг Улаанбаатар хотоос урьж ирүүлэн сумын иргэд, багачуудад бясалгалын дасгал заалгалаа. Нийт 26 хүн хамрагдсан.

# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:











05 дугаар сарын 28-ны өдөр сумын ЗДТГазар, Соёлын төв, ЭМТөв, Цагдаагийн хэсэгтэй хамтран 2-р багийн иргэдэд явуулын үйлчилгээ зохион байгууллаа. Тус арга хэмжээнд иргэд болон хүүхэд багачуудын дунд АХА тэмцээн, Номын сангийн иж бүрэн үйлчилгээ, ОНСТ-ын музейг VRBox-оор үзүүлэх, гарын авлага тараах, иргэдийн угийн бичгийн хөтлөлтийн судалгаа, 2024 оны ОНХСанд иргэдээс санал авах, амбулаторийн үзлэг оношилгоо авах зэрэг үйлчилгээнүүдийг 44 хүнд үзүүлж ажиллаа. Оршин суугчдад эрүүл мэндийн үйлчилгээ явуулын амбулаторийн үзлэг оношилгоог 16 хүнд хийгдсэн байна.

# ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР:

1. 2023 оны 03 дугаар сарын 24 ны өдрийн А/23 захирамжаар “Малын сэг зэм устгах, халдваргүйжилтийг хийх” ажлын хүрээнд “Хилийн Дэлгэрэх”ХХК-тай 2023 оны 03 дугаар сарын 29-нөөс 05 дугаар сарын 10 ны өдөр хүртэл гэрээ байгуулсан /Нийт үнэ-6,514,000/ төгрөг.

2. 2023 оны 04 дүгээр сарын 26 ны өдрийн А/39 захирамжаар Сургуулийн “Үдийн хоол”-ны ширээ сандал шинэчлэх ажлын хүрээнд “Хөгжих лүн тал” ХХК-тай 2023 оны 05 дугаар сарын 23-наас 08 дугаар сарын 23 ны өдөр хүртэл гэрээ байгуулсан. /Нийт үнэ- 8,500,000/ төгрөг.

3. Сумын экопаркийн 2 га талбайг хашиx ажлыг Дүүрэн зул ХХКомпани нь нээлттэй тендэр шалгаруулалтанд тэнцэж гэрээг 2023 оны 05 дугаар сарын 30-ний өдөр байгуулна. /Нийт үнэ-37,000,000/ төгрөг.

4. Сумын төвд Камерь шинээр авах, засварлах ажлын гэрээг 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Их Зэст Хөгжил ХХК-тай байгуулсан. /Нийт үнэ-20,000,000/ төгрөг.

5. Аймгийн хөрөнгө оруулалтаар тус сумын 154-р байрны доод техникийн давхрын инженерийн шугам сүлжээг бүрэн шинэчлэх ажил эхэлсэн.



# ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТАЛААР:

## ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

8 зээлдэгчийн 173,582,373.00 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс:

- 2022 онд олгосон 94,909,670.00 төгрөг
- 2021 оны 2 зээлдэгчийн 47,262,706.00 төгрөгийн үлдэгдэл
- 2015 оны 1 зээлдэгчийн 12,932,475.00 төгрөгийн үлдэгдэл /муу зээл/
- 2013 оны 4 зээлдэгчийн 18,477,522.00 төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- **Хүрсэн түвшин:**
- 8 Зээлдэгчийн мэдээлэл Монгол банкинд 100 % холбогдсон.
- 6 зээлдэгчийн 34,302,807,00 төгрөгийн зээл барагдсан
- Өнөөдрийн байдлаар хоршоо хөгжүүлэх санд **41,125,000.00** / дөчин нэгэн сая нэг зуун хорин тав / төгрөг төвлөрсөн байна.

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:

### Амбулаторийн үйлчилгээ:

- Нийт үзлэг-208
- Амбулаторийн үзлэг -104
- Үүнээс:
- Идэвхитэй хяналт -7
- Өдрийн эмчилгээ-4
- Нярайн эргэлт-4 хүүхэд

Урьдчилан сэргийлэх үзлэгт-139
эрэгтэй-56 хүн
эмэгтэй-83 хүн

### Түргэн тусламжийн дуудлагын төрөл, тоо хэмжээ:

- Нийт дуудлага -26
- Алсын дуудлага -12
- Төвийн дуудлага - 14
- Том хүн -20
- Хүүхэд-6
- Осол гэмтэл-0

### Стационарийн үйл ажиллагаа:

- Хэвтэн эмчлүүлэгчид нийт-3
- Дотор -3
- Хүүхэд -0
- Халдварт-0

### Лабораторийн үзлэгийн тоо: 79 /давхардсан тоо/

-Эмэгтэйчүүдийн урьдчилан сэргийлэх үзлэг-75 хүн

Эсийн шинжилгээ-17 хүн хамрагдсан.

2 сараас 2 насны нярайн вакцинд хамрагдсан тоо-8 хүүхэд

# ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР:

**Хаваржилтын ерөнхий нөхцөл байдал:**
Энэ хавар өөрийн сумын 88 малчин, 72 мал бүхий өрхийн 72035, гадны отрын 1540 нийт 73575 толгой мал хаваржиж байна. Нийт 29020 мал төллөхөөс 2023.05.12-ний байдлаар 19482 мал төллөн унага 63, тугал 120, хурга 15349, ишиг 3950 толгой нийт 19482 төл хүлээн авсан. Мал төллөлт 67 %, төл бойжилт 100 %-тай байна.

**-Отор нүүдэл, зөвшөөрөлгүй нэвтэрсэн өрх, малын тоо:**
Төв аймгийн Баян сумын 1 өрх, Дундговь аймгийн 6 өрхийн болон эзэнгүй нийт 10000 гаруй толгой мал отроор ирж хаваржиж байгаа бөгөөд тус айлуудад бэлчээр нутаг чөлөөлөх тухай сумын Засаг даргын албан мэдэгдэл хүргүүлсэн. Одоогийн байдлаар зөвшөөрөл авсан отрын малчин байхгүй байна.

**-Малын өвчний байдал, тайван эсэх:**
Одоогоор малын өвчлөл гараагүй тайван байна.

**-Цаг агаарын аюулт үзэгдлийн мэдээ дамжуулж байгаа мэдээлэл**:
Цаг агаарын мэдээ болон аюулт үзэгдлийн мэдээг Баянтал ХААТ дундын групп, багуудын Засаг дарга нар болон багийн цахим хаягаар мэдээллийг тогтмол хүргэж хэвшсэн. Мөн WHAT 3 WORDS апликэйшний талаар малчдад мэдээлэл хүргэсэн.

**Бусад**
2023 оны 05 дугаар сарын 18-ны өдөр ЗДТГазрын Хүнсний зориулалтаар ашиглах боломжтой зоорийг сонирхсон иргэн, аж ахуй нэгжид түрээслэх нээлттэй тендерийг 14 хоногийн хугацаатай зарлаж, цахимд зарыг байршуулсан байна.



# БОЛОВСРОЛЫН ТАЛААР:

•1. 2023 оны 05 дугаар сарын 15-аас 19 өдрүүдэд **“ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, БАГШИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ”** зохион байгуулагдлаа. Уг үнэлгээнд 9 багш, 4 анги сонгогдон бага ангийн 3 багш, дунд ангийн 6 багш, бага ангийн математик, монгол хэл, биеийн тамир, англи хэл агуулгаар, дунд ангийн монгол хэл, математик, хөгжим, түүх агуулгаар үнэлгээнд хамрагдсан.

•2. 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдсан “Замын хөдөлгөөний цагаан толгой” тэмцээнд 10 хүүхэд, 2 багш, 2 эцэг эх амжилттай оролцлоо.

•3. 2023 оны 05 дугаар сарын 24-ны өдөр жилийн ажлын тайлант тоглолт сумын соёлын төвд амжилттай зохион байгуулагдлаа. Тус тоглолтод 3 бүлгийн 76 хүүхэд 100% хамрагдсан ба хөтөлбөрийн дагуу 28 үзүүлбэрийг тайлагнан амжилттай үзүүллээ.


















# СОЁЛ УРЛАГИЙН ТАЛААР:

1. 05 дугаар сарын 15-ны өдөр Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас “Хүүхдэдээ үлгэрлэн дуурайх аав ээж нь байя” сэдэвт гэр бүлийн өдөрлөгийг зохион байгууллаа.
2. ОУ-ын Музейн өдрийг тохиолдуулан 5-р сарын 18-ны өдөр ЕБС-ийн 3А ангийн сурагчдад ОНСТ- ын музей үзүүлж “Миний үзсэн музей” сэдэвт гар зургийн уралдаан мөн Соёмбо тэмдгийн нэр бүтцийн талаар сургалт зохион байгуулж Соёмбо тэмдгийг нэрлэн эвлүүлж наах уралдааныг зохион байгуулж тус уралдаанд сурагч Б.Тэмүүлэн, Г.Гоо-Үжин нар шалгарлаа.
3. 05 дугаар сарын 19-ны өдөр “Номын баяр - 2023“ арга хэмжээний хүрээнд сумын номын санд хамгийн их ном уншиж үйлчлүүлсэн 5А ангийн сурагч Э.Ариунзаяа “Тэргүүний уншигч” Нацагдорж тэмдгээр шагнууллаа.









# СОЁЛ УРЛАГИЙН ТАЛААР:



Говьсүмбэр аймгийн ЗДТГ, БШУГ, Хэлний бодлогын салбар зөвлөлөөс санаачлан зохион байгуулсан МУГБагш Н.Түмэн-Өлзийгийн нэрэмжит монгол бичгийн олимпиад 2023оны 05 сарын 23-25 хооронд ЕБС-ийн сурагч, мэргэжлийн багш, төрийн албан хаагч, иргэн ангиллаар Хичээнгүй бичиг, Бийрэн бичлэгийн төрлөөр амжилттай зохион байгуулагдаж, тус олимпиадад Баянтал сумын Соёлын төв хичээнгүй бичсэн бичвэрээр оролцож төрийн албан хаагч ангиллын Дэд байр эзэлсэн байна.

2023 оны 5 сарын 27 ний өдөр Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын зугаадугаар зөвлөгөөн болсон байна.






"БОРЖИГИНЫ ТҮҮХИЙГ ТОЛЬДОХУЙ" ЗУРГААДУГААР ЗӨВЛӨГӨӨН

**Зөвлөгөөний хүрээнд:**

- Зөвлөгөөний нээлт
- Боржигин хошууны түүхэн замнал товч танилцуулга
- Танин мэдэхүйн асуулт хариултын АХА тэмцээн
- Багуудын дундах хөгжөөнт буухиа тэмцээн
- Багуудын гэрийн даалгавар ( Боржигин хошууны түүх, ёс уламжлалын талаарх товч мэдээлэл бэлтгэн хүргэх)
- Шагнал гардуулах ёслол
- Цэнгүүн

**Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Соёлын төв**



"БОРЖИГИНЫ ТҮҮХИЙГ ТОЛЬДОХУЙ" ЗУРГААДУГААР ЗӨВЛӨГӨӨН

**Маршрут:**

- Нээлт ( Сэцэн хан аймгийн Боржигин сэцэн вангийн хошуу тамгын туурь )
- "Цайны зам" тэмээний хөшөө
- Хүүхдийн овоо
- Хонгилтойн агуй
- Үзүүрийн агуй
- Цагаан өвгөн
- Дагва сүндэл бурхан ( Эрчүүд ) алхалт
- Дунд уул ( Эмэгтэйчүүд ) алхалт
- ( Отоглох буудаллах газрыг цаг агаарын байдлыг харгалзан тухайн үед тогтоно.)
- Хийдийн туурь, Цагаан дарь эх, Хүслийн хад
- Хаалт ( Цоорхойн рашаан )

**Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Соёлын төв**







***МЭДЭЭНИЙ ЭХИЙГ БЭЛТГЭСЭН ЗДТГАЗРЫН ДАРГА В.ГАНТУЯА***